



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар АР30

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.12, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.3, 42 дугаар зүйлийн 42.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны Улсын төсвийн төсөлд санал оруулах “Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж цэвэр усан хангамж, усан сангийн байгууламж”-ын барилга угсралтын ажлын нэг маягийн зураг төслийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

дарга: С.Лхагвачулуун Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн

дарга: Ш.Ариунболор Аймгийн ерөнхий архитектор

Гишүүн: Х.Баярбаатар Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

2. Ажлын хэсгийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (С.Лхагвачулуун)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСOMЖАВ